



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 05 сарын 06 өдөр

Дугаар 217

Улаанбаатар хот

Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч
/брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай
зөвшөөрлийг сунгах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 10 дугаар зүйлийн 10.1.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 69 дүгээр тогтоолоор баталсан “Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн тусгай зөвшөөрлийн түр журам”-ын 7.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хаантэлмэн ХААБ” ХХК-ийн хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаагаар сунгасугай.

2. Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сунгасантай холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг “Хөдөө аж ахуйн бирж” ТӨХХК /Х.Баатар/, “Хаантэлмэн ХААБ” ХХК /О.Батсүлд/ нарт тус тус үүрэг болгосугай.

1/ Харилцагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэх;

2/ Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох журамд заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлэх;

3/ Энэхүү тогтоолтой нийцүүлэн холбогдох дүрэм, журам, биржийн арилжааны системд зохих өөрчлөлтийг оруулж, зохицуулалтын үйлчилгээний хөлсийг Хорооны дансанд сар бүрийн эцэст тогтмол төвлөрүүлж ажиллах.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН